

2018 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн Эрүүл мэндийн сайдын 05 албан даалгавар нь “Нярай болон бага насны хүүдийн эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайжируулах тухай юм. 2018 оны эхний хагас жилийг, өнгөрсөн үеийнхтэй харьцуулахад 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 20, нялхасын эндэгдэл 8-н тохиолдлоор тус тус өссөн байна. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.8-д дэвшүүлсэн “Хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжийг сайжируулахад нэн тэргүүнд анхаарна” гэсэн зоирилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилт хангалтгүй байгаа тул нярай болон бага насны хүүхдийн тусламж, үйлчилгээний чадавхийг нэмэгдүүлж, оношилгоо, эмчилгээний багаж хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулж ажиллах. Эрүүл мэндийн сайдын 2009 оны 307, 2014 оны 182, 335, 399, 333, 2016 оны А/291, 2017 оны А/269,297 дугаар тушаалуудын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг даалгаж байна.Тус төв нь 05 албан даалгаврын дагуу 8-н зүйлтэй ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.